

Захиргааны хэм хэмжээний  
актын улсын нэгдсэн бүртгэлд  
2025 оны 01 сарын 24-ны  
өдрийн 3084 дугаарт бүртгэв.



МОНГОЛ УЛСЫН  
АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН  
САЙДЫН ТУШААЛ

2024 - 12 - 27

ЦТУВААН А/102

Улаанбаатар

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсэг, Ашигт малтмалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, 10.2 дахь хэсэг, Засгийн газрын 2021 оны "Журам батлах эрх олгох тухай" 381 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Сонгон шалгаруулалтын журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Сонгон шалгаруулалтын талбайн босго үнийг нэг гектар тутамд 7000 (долоон мянган) төгрөг байхаар тогтоосугай.

3. "Сонгон шалгаруулалтын журам"-ыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхийг Төрийн нарийн бичгийн дарга (С.Жавхланбаатар)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Геологи, уул уурхайн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Ашигт малтмал, газрын тосны газар, Үндэсний геологийн албанд тус тус даалгасугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар (Б.Өнөмөнх)-д даалгасугай.

6. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн "Журам батлах тухай" А/48 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

ЦТУВААН

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС  
БАЯЛГИЙН ЯАМ  
Бүртгэлийн дугаар 52  
**ХУУЛБАР ҮНЭН**  
(Албан тушаалын нэр)  
(гарын үсэг) (гарын үсгийн тайлал)  
2024 оны 12 дугаар сарын 30

1508 01 0077

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын  
2024 оны 12 сарын 27-ны өдрийн А/102  
дугаар тушаалын хавсралт

## СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЖУРАМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү "Сонгон шалгаруулалтын журам" (цаашид "Журам" гэх)-ын зорилго нь Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг (цаашид "Тусгай зөвшөөрөл" гэх) олгох, сонгон шалгаруулалтыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Ашигт малтмалын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, энэхүү журам, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг зохион байгуулна.

1.3. Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг олон нийтэд ил тод, нээлттэй, шударга өрсөлдөх, тэгш боломжоор хангах зарчмыг баримтлан зохион байгуулна.

1.4. Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын Кадастрын асуудал хариуцсан нэгж тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг Ашигт малтмалын тухай хууль болон энэ журмын дагуу цахим хэлбэрээр зохион байгуулна.

1.5. Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалттай холбоотой энэхүү журмаар зохицуулаагүй асуудлыг Ашигт малтмалын тухай хуулиар зохицуулна.

### ХОЁР. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ


2.1. Сонгон шалгаруулалтад оролцогч хүсэлт илгээхдээ доорх хэсгийг баримтална.

2.1.1. оролцогч сонгон шалгаруулалтын төрийн худалдан авах ажиллагааны газрын ( ) цахим системд нэвтэрч (цаашид Цахим систем гэх), Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 25.1.5-д заасан үйлчилгээний хураамжийг урилгад заасан зааврын дагуу төлснөөр тухайн сонгон шалгаруулалтын талбайн ерөнхий мэдээлэлтэй танилцана;

2.1.2. оролцогч нь тухайлсан талбайн сонгон шалгаруулалтад оролцоходоо талбайн босго үнийг цахим системд илгээж баталгаажуулснаар журмын 2.1.3-д заасан баримт бичиг, үнийн санал илгээх эрх үүснэ;

2.1.3. Ашигт малтмалын тухай хуулийн 18.1-д заасны дагуу баримт бичгийн бүрдэлийг ханган, үнийн саналын хамт цахим системд илгээж

2.1.4. оролцогч нь хүсэлт илгээхдээ цахим системд босго үнийг төлж, босго



үнэ баталгаажсаны дараа үнийн санал болон техникийн саналыг (Журмын 1, 2, 3 дугаар хавсралтуудын хамт) боловсруулан, "pdf" форматад тод хөрвүүлэн хүсэлт хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө илгээнэ;

2.1.5.оролцогч энэ журмын 2.1.4-д заасан сонгон шалгаруулалтын материалыг илгээснээр тусгай кодоор баталгаажсан, огноо бүхий хүсэлт хүлээн авсан тодорхойлолт оролцогчд илгээгдэж, бүртгэл хүчинтэй болно.

## ГУРАВ. ОРОЛЦОГЧИЙН ҮНИЙН БОЛОН ТЕХНИКИЙН САНАЛЫГ ҮНЭЛЭХ АРГАЧЛАЛ

3.1.Сонгон шалгаруулалтын үнийн саналыг үнэлэхдээ дараах аргачлалыг баримтална:

3.1.1.хамгийн өндөр үнийн санал ирүүлсэн оролцогчид 60 (жаран) оноо бусад оролцогчдын ирүүлсэн үнэ бүрийг цахим системд илгээсний дагуу хамгийн өндөр үнэтэй харьцуулж доорх томъёогоор тооцоолно;

Бусад оролцогчийн үнийн санал  
Бусад оролцогчийн үнийн саналын оноо = ----- х 60  
Хамгийн өндөр үнийн санал

3.1.2.оролцогчийн буюу сонгон шалгаруулалтын үнийн саналын оноо нь 20 (хорин) оноонд хүрээгүй техникийн саналд Ашигт малтмалын тухай хуулийн 20.1.2-д заасны дагуу үнэлгээ хийхгүй, цахим хуудсанд байршуулж нийтэд нээлттэй мэдээлнэ.

3.1.3.оролцогчийн үнийн саналын үнэлгээний үр дүнг цахим систем автоматаар тухайн сонгон шалгаруулалтад оролцож буй оролцогчдод мэдээлэх бөгөөд комиссын нарийн бичгийн дарга тэмдэглэл хөтлөн комиссын дарга, гишүүдэд танилцуулна.

3.2.Сонгон шалгаруулалтын оролцогчийн техникийн саналыг үнэлэхэд дараах аргачлалыг баримтална.

3.2.1.комисс нь сонгон шалгаруулалтын үнийн саналын оноо нь 20 (хорин)-оос дээш оноо авсан оролцогчийн техникийн саналыг 40 (дөч) хүртэл оноогоор үнэлнэ;


3.2.2.оролцогчдоос ирүүлсэн техникийн саналыг (Журмын 4 дүгээр хавсралт)-т заасны дагуу үнэлнэ;

3.2.3.оролцогч нь Ашигтмалын малтмалын тухай хуулийн 18.1-д заасан шаардлагын дагуу баримт бичгийг ирүүлээгүй тохиолдолд Ашигт малтмалын тухай хуулийн 20.2.2-д заасны дагуу техникийн саналыг үнэлэхгүй болно.

3.3.Үнийн болон техникийн саналын оноог нэгтгэхэд дараах аргачлалыг баримтална:

3.3.1.комиссын нарийн бичгийн дарга нь оролцогчдоос ирүүлсэн үнийн болон техникийн саналыг журмын 3.1, 3.2-д заасны дагуу үнэлсэн, үнэлгээний оноог нэгтгэж, хуралдааны тэмдэглэл үйлдэнэ;

3.3.2.сонгон шалгаруулалтад хоёр болон түүнээс дээш оролцогч нь нийт оноо нь тэнцсэн тохиолдолд Ашигт малтмалын хуулийн 20.3.2-д заасны дагуу илүү үнийн санал ирүүлсэн оролцогчид тусгай зөвшөөрөл олгох тухай дүгнэлтийг гаргана.



## ДӨРӨВ. ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ШАЛГУУР НӨХЦӨЛ

4.1.Шалгарсан оролцогч нь Ашигт малтмалын тухай хуулийн 20.5.5-д заасан нөхцөл үүссэн тохиолдолд нийлбэр оноогоор хоёрт орсон оролцогчид тусгай зөвшөөрлийг олгож болно;

4.2.Журмын 4.1-д заасны дагуу шалгарсан оролцогчийн нийлбэр онооноос хоёрт орсон оролцогчийн нийлбэр оноо 8 хувиас хэтрээгүй тохиолдолд хэрэглэнэ;

4.3.Шалгарсан оролцогч нь энэ журмын 4.1, 4.2-д заасан үнийн саналд тусгасан мөнгөн дүнг төлөөгүй тохиолдолд Ашигт малтмалын тухай хуулийн 20.5.6-д заасны дагуу оролцогчид босго үнийг буцаан олгохгүй.

4.4.Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалыг зохион байгуулахдаа Ашигт малтмалын тухай хуулийн 20 дугаар зүйлд заасныг баримтална.

## ТАВ.СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН БОЛОН ОРОЛЦОГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

5.1.Комиссын бүрэлдэхүүн нь дараах шаардлагыг хангасан байна:

5.1.1.Ашигт малтмалын тухай хуулийн 10.3-д заасны дагуу геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар сонгон шалгаруулалтын комисс (цаашид "Комисс" гэх)-ын бүрэлдэхүүнийг батална.

5.1.2.комисс нь дарга, нарийн бичгийн дарга болон гишүүдээс бүрдсэн нийт 6 (зургаа) гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Нарийн бичгийн дарга нь саналын эрхгүй байна;

5.1.3.сонгон шалгаруулалтын оролцогчид тусгай зөвшөөрөл олгох тухай дүгнэлтийг Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гаргана.


5.1.4.саналын эрхтэй комиссын гишүүн нь хууль эрх зүй, геологи, уул уурхайн салбарын мэргэжил эзэмшсэн, геологийн судалгаа, хайгуулын төлөвлөгөө, тайланг үнэлэх мэргэжлийн чадвар, туршлагатай Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Үндэсний геологийн алба болон салбарын төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулна;

5.1.5.комиссын саналын эрхтэй гишүүд нь 4-өөс дээш байж, хуульд заасан хугацаанд үнэлгээ хийж, тоон гарын үсгээр баталгаажуулан цахим системд илгээснээр комиссын үнэлгээ хүчин төгөлдөр болно.

5.2.Комисс нь дараах эрх, үүрэгтэй байна:

5.2.1.сонгон шалгаруулалтыг урилгад заасан хугацаанд эхлүүлэх;

5.2.2.сонгон шалгаруулалтын үйл явцын гэмдэглэлийг үйлдэх;



5.2.3.комиссын гишүүд нь оролцогчийн ирүүлсэн техникийн саналыг Төрийн болон албаны нууцын тухай, Байгууллагын нууцын тухай, Хувь хүний нууцын тухай хууль болон бусад хуульд заасан мэдээллийг задруулахгүй байх;

5.3.Комиссын дарга, гишүүд нь дараах эрх, үүрэгтэй:

5.3.1.Комиссын дарга нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

5.3.1.1.комиссын хурлыг удирдаж, үйл ажиллагаатай холбогдуулан зохион байгуулалтын арга хэмжээг тухай бүр шуурхай авч нэгдсэн удирдлагаар хангах;

5.3.1.2.комиссын үйл ажиллагаанд хяналт тавьж, холбогдох баримт бичигтэй тухай бүр танилцах, комиссын гишүүдэд шаардлага тавьж ажиллах;

5.3.2.Комиссын гишүүд нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

5.3.2.1.комиссын хуралд саналын эрхтэйгээр холбогдох үнэлгээ хийж оролцох;

5.3.2.2.ашигт малтмалын тухай хуульд заасан хугацаанд багтааж үнэлгээ хийх;

5.3.2.3.комиссын хуралд тогтмол оролцож, комиссын хэвийн, тасралтгүй үйл ажиллагааг хангаж ажиллах;

5.3.2.4.комиссын хуралдаанаар хэлэлцэх оролцогчдоос ирүүлсэн хүсэлтэд мэргэжлийн санал, дүгнэлтийг гаргах;

5.3.2.5.комиссын гишүүн өөрийн биеийн эрүүл мэндийн шалтгаан болон бусад шалтгаанаар комиссын гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлт гаргах.

5.3.2.6.ашиг сонирхлоос ангид байх.

5.4.Комиссын нарийн бичгийн дарга нь дараах чиг үүрэгтэй байна:

5.4.1.Нарийн бичгийн дарга нь үнэлгээ хийхгүй бөгөөд сонгон шалгаруулалттай холбоотойгоор хурлын тэмдэглэл хөтлөх, дүгнэлтийн тушаалыг байгууллагын архивд хүлээлгэн өгөх;

5.4.2.сонгон шалгаруулалтын үнэлгээний нэгтгэлийг бэлтгэж, комисст танилцуулах;


5.4.3.сонгон шалгаруулалтын бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах;

5.4.4.комиссын гишүүдийг шаардлагатай мэдээллээр хангах;

5.4.5.эрх бүхий байгууллагаас комисстой холбоотой асуудлаар маргаан шийдвэрлэх, хяналт, шалгалт хийх тохиолдолд шаардлагатай баримт, мэдээллийг тухай бүрд нь гаргаж өгөх.

5.5.Оролцогч нь дараах эрх, үүрэгтэй байна:

5.5.1.сонгон шалгаруулалтын журамтай танилцаж судалсан байх;



5.5.2.сонгон шалгаруулалтын урилгаар зарласан 1 (нэг) болон түүнээс олон талбайд хүсэлт ирүүлэх;

5.5.3.цахим системд ирүүлсэн баримт бичгийн бүрдэл, үнэн зөвийг бүрэн хариуцах;

5.5.4.сонгон шалгаруулалтын үйл ажиллагаатай холбоотой санал хүсэлтийг Ашигт малтмалын тухай хуульд заасны дагуу гаргах.

### ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ

6.1.Энэ журмыг зөрчсөн этгээдэд дараах хариуцлага хүлээлгэнэ:

6.1.1.энэхүү журамд заасныг зөрчиж, эрх мэдлээ урвуулан ашигласан бол Төрийн албаны тухай хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ;

6.1.2.сонгон шалгаруулалтад оролцогч сонгон шалгаруулалтын үнэлгээтэй холбоотой санал хүсэлтийг Ашигт малтмалын тухай хуульд заасны дагуу гаргаж болно.

---oOo---



### МЭДЭЭЛЭЛТЭЙ ТАНИЛЦАХ ЗӨВШӨӨРӨЛ

Огноо

..... /аж ахуй нэгжийн нэр/ нь ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох Сонгон шалгаруулалтын ..... дугаар талбайд сонгон шалгаруулалтад оролцож байгаа тул сонгон шалгаруулалтын комисст улсын бүртгэлийн ерөнхий газрын хуулийн этгээдийн мэдээлэл болон татварын албаны тодорхойлолттой танилцахад зөвшөөрөл олгож байна.

Албан ёсны шуудангийн хаяг: .....

Эрх бүхий албан тушаалтны утас: .....

Цахим шуудангийн хаяг: .....

Жич: Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, дүрмийн хуулбар, Монгол Улсад татвар төлөгч болох тухай тодорхойлолтыг хавсаргах.



Зөвшөөрсөн:

Эрх бүхий албан тушаалтан...../...../

Гарын үсэг

Нэр

Сонгон шалгаруулалтын  
журмын 2 дугаар хавсралт

**ТӨСӨЛД ОРОЛЦОХ МЭРГЭЖЛИЙН БОЛОВСОН ХҮЧНИЙ ЖАГСААЛТЫН  
МАЯГТ**

202 ... оны ... -р сарын ... -ны өдөр ..... аймгийн ..... сумын нутаг ..... га бүхий  
..... нэртэ  
й  
талбайд ус, газрын тос, уламжлалт бус газрын тосноос бусад ашигт малтмалын хайгуул хийх зөвшөөрөл олгохоор зарласан  
..... талбайн кодтой сонгон шалгаруулалтанд оролцохоор ирүүлсэн төсөлд оролцох мэргэжлийн боловсон хүчний  
жагсаалтыг  
гаргаж байна.

Д/д	Овог нэр	Албан тушаал	Үндсэн ажилтан	Гэрээт ажилтан	Мэргэжил	Мэргэжлийн зэрэг	Нийгмийн даатгал төлөгдсөн эсэх	Тайлбар
1								
2								
3								
4								
5								





Сонгон шалгаруулалтын  
журмын 3 дугаар хавсралт

### ТӨСӨЛД ХЭРЭГЛЭГДЭХ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЖАГСААЛТЫН МАЯГТ

202 ... оны ... -р сарын ... -ны өдөр ..... аймгийн ..... сумын нутаг ..... га бүхий  
..... нэртэ  
й

талбайд ус, газрын тос, уламжлалт бус газрын тосноос бусад ашигт малтмалын хайгуул хийх зөвшөөрөл олгохоор зарласан  
..... талбайн кодтой сонгон шалгаруулалтанд оролцохоор ирүүлсэн төсөлд оролцох тоног төхөөрөмжийн жагсаалтыг  
гаргаж байна.

Д/д	Техник, тоног төхөөрөмжийн нэр	Марк	Улсын бүртгэлийн дугаар	Зориулалт	Өмчийн хэлбэр	
					Өөрийн	Гэрээт
1						
2						
3						
4						
5						



**АШИГТ МАЛТМАЛЫН ХАЙГУУЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ  
СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ТЕХНИКИЙН САНАЛЫН ҮНЭЛГЭЭ**

№	Шалгуур үзүүлэлт	Үнэлгээ
	<b>Төслийн техникийн баримт бичгийн үнэлгээ</b>	<b>5-40</b>
<b>1</b>	<b>Талбайн геологи, хайгуулын ажлын төлөвлөлт /3 жилээр/</b>	<b>1-15</b>
	Геологи, хайгуулын ажлыг оновчтой, гүйцэд төлөвлөсөн: Талбайн геологийн тогтцыг бүрэн судалж, байж болох бүх төрлийн ашигт малтмалын хэтийн төлөвийн үнэлгээ өгсөн байх, арга аргачлалд судалгааны ажил зохимжтой зөв төлөвлөгдсөн байх.	10-15
	Геологи хайгуулын ажил төлөвлөсөн: Талбайн геологийн тогтцыг гүйцэт судлаагүй, хайгуулын шатны ажлуудыг ерөнхийд нь төлөвлөсөн байх.	5-10
	Геологи, хайгуулын ажлын төлөвлөлт хангалтгүй: Хайгуулын талбайн мэдээлэлтэй бүрэн танилцаагүй, судалгааны ажлын зорилго тодорхой бус, төлөвлөсөн хайгуулын ажлын арга, аргачлал, ажлын хэмжээ оновчтой бус.	1-5
<b>2</b>	<b>Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажил, зардлын хэмжээ, хэрэгжүүлэх хугацааг тооцсон төлөвлөлт, мэдээлэл</b>	<b>1-8</b>
	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажилыг бодитой, бүрэн хангалттай төлөвлөсөн: Хайгуулын ажил гүйцэтгэхээр төлөвлөсөн уулын малталт, өрөмдлөгийн ажлын хэмжээнд төлөвлөсөн зардал хангалттай төлөвлөгдсөн байх.	6-8
	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажилыг алдаатай төлөвлөсөн байх: Хайгуулын ажил гүйцэтгэхээр төлөвлөсөн уулын малталт, өрөмдлөгийн ажлын хэмжээнд төлөвлөсөн зардал хангалтгүй, дутуу төлөвлөгдсөн байх.	4-6
	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажилыг бодитой төлөвлөсөн /бүрэн хангалтгүй төлөвлөсөн: Хайгуулын ажил гүйцэтгэхээр төлөвлөсөн уулын малталт, өрөмдлөгийн ажлын хэмжээнд буруу төлөвлөсөн зардал хангалтгүй байх.	1-3
<b>3</b>	<b>Мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан байдал болон тэдгээрийн туршлага чадвар</b>	<b>2-9</b>
	<b>Мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан байдал</b>	<b>1-5</b>
<b>3.1</b>	Төслийг гүйцэтгэх өөрийн үндсэн ажилтантай буюу ИТА болон Геологич 100 хувь хангагдсан эсэх (НДШ төлөлтийн тодорхойлолт, бусад нотолгоотой байх).	4-6
	Төслийг гэрээгээр гүйцэтгүүлэх бол (ИТА болон Геологичид <99 хувь).	1-3
	<b>Мэргэжлийн боловсон хүчний туршлага, чадвар</b>	<b>1-4</b>
<b>3.2</b>	Монгол Улсын Зөвлөх геологич ажилладаг	4
	Монгол Улсын Мэргэжсэн геологич ажилладаг	3
	Аль аль нь байхгүй Мэргэжлийн геологич ажилладаг	1-2
<b>4</b>	<b>Төсөлд ажиллах техник тоног төхөөрөмжийн мэдээллийн үнэлгээ</b> (Гэрээ болон хавсралтаар баталгаажсан байна.)	<b>1-8</b>

9024070570 9129294 СБТ-25808

Геологи, хайгуулын ажил гүйцэтгэх өөрийн өмчийн өрмийн, геофизикийн болон бусад техник тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан бол (өрөм, геофизикийн багажийг нотлох хавсралтууд баримт бичиг)	7-8
Геологи, хайгуулын ажил гүйцэтгэх өрөм, геофизикийн болон бусад техник тоног төхөөрөмжийг түрээсэлдэг эсвэл гэрээгээр хайгуулын ажил гүйцэтгүүлэх бол (Түрээсийн болон хамтран ажиллах гэрээ)	4-6
Геологи, хайгуулын ажил гүйцэтгэх техник тоног төхөөрөмжийн мэдээлэл ирүүлээгүй болон алдаатай, ирүүлсэн бол.	1-3
<b>НИЙТ ОНОО</b>	<b>40</b>

--oOo--

АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС  
 БАЯЛГИЙН ЯАМ  
 Бүртгэлийн дугаар 52

**ХУУЛБАР ҮНЭН**  
 (Албан тушаалын нэр)

(Гарын үсэг) (Гарын үсгийн тайлал)  
 2024 оны 12 дугаар сарын 30